



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2017 оны 09 сарын 04 өдөр

Дугаар А/346

Улаанбаатар хот

Төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 8.1.3 дахь заалт, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 3.1.6 дахь зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Томуу, томуу төст өвчний эрсдэлээс сэргийлэх бэлэн байдлын төлөвлөгөөг хавсралт ёсоор баталсугай.

2. Томуу, томуу төст өвчний эрсдэлээс сэргийлэх бэлэн байдлын төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахыг Төрийн нарийн бичгийн дарга /Д.Очирбат/, хэрэгжилтийг ханган ажиллахыг холбогдох газар, хэлтсийн дарга нар, Тусгай мэргэжлийн төв, төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн дарга захирал, аймаг, Нийслэлийн эрүүл мэндийн газрын дарга нарт даалгасугай.

3. Төлөвлөгөөний хэрэгжилтийг жил бүрийн 10 дугаар сарын 1-ээс 6 дугаар сарын 1-ний хооронд 14 хоног тутамд Тандалт, шуурхай удирдлагын хэлтэст ирүүлэхийг үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Б.Баярт/-т даалгасугай.

САЙД



А.ЦОГЦЭЦЭГ

081099



## ТОМУУ, ТОМУУ ТӨСТ ӨВЧНИЙ ЭРСДЭЛЭЭС СЭРГИЙЛЭХ БЭЛЭН БАЙДЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

### 1. Үндэслэл

Томуу, томуу төст өвчин (ТТӨ)-ий жил бүрийн дэгдэлт нь богино хугацаанд олон хүнийг хамран өвчлүүлж, ноцтой хүндрэл, ялангуяа уушигины үрэвсэлд хүргэдгээрээ нийгмийн эрүүл мэндийн анхаарал татсан асуудал болдог. Томуугийн дэгдэлтийн үед гарах эндэгдэл нь өндөр настан, зүрх, уушги, бөөр бодисын солилцооны архаг хууч өвчтэй дархлааны дуталтай хүмүүст голчлон тохиолддог<sup>1</sup>.

Сүүлийн 3 жилд томуугийн вирус 43 дугаар долоо хоногоос хүн амын дунд эргэлтэд орж, 22 дугаар долоо хоног хүртэл идэвхтэй эргэлтэд байж, 5-аас 11 дүгээр долоо хоногт хамгийн өндөр түвшинд хүрсэн байна. 2014/15 оны томуугийн улиралд томуугийн А (H1N1), 2016/17 онд А(H3N2) вирус хүн амын дунд давамгайлан эргэлтэд байжээ.

### 2. Зорилго:

Улсын хэмжээнд томуу, томуу төст өвчнийг тандах, хянах, дэгдэлтийн үеийн хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах зорилготой.

### 3. Хамрах хүрээ:

- Эрүүл мэндийн яам
- Тусгай мэргэжлийн төв, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг (Халдварт өвчин судлалын үндэсний төв, Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, Эрүүл мэндийн хөгжлийн төв, Улсын нэгдүгээр төв эмнэлэг, Улсын хоёрдугаар төв эмнэлэг, Улсын гуравдугаар төв эмнэлэг)
- Нийслэлийн эрүүл мэндийн байгууллага (Нийслэлийн эрүүл мэндийн газар, Дүүргийн эрүүл мэндийн төв, Нэгдсэн эмнэлэг, Өрхийн эрүүл мэндийн төв)

<sup>1</sup> Халдварт өвчний хяналтын лавлах, 2010

- Аймгийн эрүүл мэндийн байгууллага (Эрүүл мэндийн газар, Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, Нэгдсэн эмнэлэг, Сумын эрүүл мэндийн төв, Өрхийн эрүүл мэндийн төв)

#### 4. ТТӨ-ий үе шат, шалгуур:

Үе шатууд	Шалгуур		
	Амбулаторийн үзлэгт ТТӨ-ий эзлэх хувь	Хэвтэн эмчлүүлэгчдийн дундах АЗЦХХ-тэй өвчтний эзлэх хувь	Хүүхдийн орны ачаалал нэмэгдсэн хувь
I (томуугийн улирал угтуулан)	4 хувь хүртэл	4 хувь хүртэл	
II (алаг, цоог дэгдэлт)	5-9 хувь	5-9 хувь	30 хүртэлх хувь
III (бүс нутгийн хэмжээний дэгдэлт)	10-14 хувь	10-14 хувь	30-65 хүртэлх хувь
IV (улсын хэмжээний дэгдэлт)	15 ба түүнээс дээш хувь	15 ба түүнээс дээш хувь	65 ба түүнээс дээш хувь

#### 5. Хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэл

- 5.1. Төлөвлөлт, зохицуулалт
- 5.2. Тандалт, халдварын сэргийлэлт хяналт
- 5.3. Эмнэлгийн тусламж үйлчилгээ
- 5.4. Эрсдэлийн үеийн харилцаа холбоо

**ТОМУУ, ТОМУУ ТӨСТ ӨВЧНИЙ ЭРСДЭЛЭЭС СЭРГИЙЛЭХ  
БЭЛЭН БАЙДЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хэрэгжүүлэгч байгууллага		
		ЭМЯ	Төрөлжсөн мэргэжлийн төв	Нийслэлийн ЭМБ
<b>I ҮЕ ШАТ. ТОМУУ, ТОМУУ ТӨСТ ӨВЧНИЙ УЛИРАЛ УГТУУЛАН (7 дугаар сарын 15-наас 9 дүгээр сарын 15)</b>				
<b>Төлөвлөлт, зохицуулалт</b>				
ТТӨ-ий хариу арга хэмжээний бэлэн байдлын төлөвлөгөөнд тодотгол хийж, бэлэн байдлыг хангах	9 дүгээр сарын 1-15	Эрүүл мэндийн байгууллагууд		
ТТӨ-ий дэгдэлтийн үед ажиллах эмч, мэргэжилтнийг томилох, албажуулах, бүртгэл судалгааг шинэчлэх	9 дүгээр сарын 15-20	ТЗУГ ЭТГ	Эрүүл мэндийн байгууллагууд	
Эмч, мэргэжилтнийг оношилгоо, эмчилгээ (ХӨЦМ, амилуулах, яаралтай тусламж), тандалт, хариу арга хэмжээ, халдварын хяналт, сэргийлэлт, эрсдэлийн үеийн харилцаа холбооны чиглэлээр сургалтын төлөвлөгөө гаргах, сургах	9 дүгээр 25-наас 10 дугаар сарын 15	Эрүүл мэндийн байгууллагууд		
ТТӨ-ий дэгдэлтийн үед нэмэлт ор, эмнэлэг дэлгэх, хүний нөөц дайчлах төлөвлөгөө гаргах	9 дүгээр сарын 1-10	ТЗУГ ЭТГ	ХӨСҮТ ЭХЭМҮТ	Засаг даргын тамгын газар Засаг даргын тамгын газар ДЭМТ/БОЭТ/ НЭ
ТТӨ-ий дэгдэлтийн үед нэмэлтээр ажиллах хувийн хэвшлийн эмнэлгийг сонгон, гэрээ байгуулах	9 дүгээр сарын 10-20	БТГ ЭТГ	НЭМГ ЭМГ	
<b>Тандалт, халдвар хяналт</b>				
ТТӨ-ий тандалтыг долоо хоног бүр хийж, эргэн мэдээллээр хангах	7 хоног бүрт	ТШУХ	ХӨСҮТ	ЭМГ ЭМГ
Улирлын томуугийн вакцинд хамрагдах эрсдэлт бүлгийн хүн амын судалгаа гаргах	9 дүгээр сарын 10	ТШУХ	ХӨСҮТ	НЭМГ/ДЭМТ/ ӨЭМТ
Улирлын томуугийн вакцины тооцоог гаргаж, захиалга, түгээлт хийх	9 дүгээр сарын 30	ТШУХ	ХӨСҮТ	НЭМГ ЭМГ

Улирлын томуугийн вакцинаар (бага насны хүүхэд, өндөр настан, эрсдэлт бүлэг, агаарын бохирдлын индекс өндөртэй бүсийн цэцэрлэгийн хүүхдүүд...) дархлаажуулах	10 дугаар сарын 1-10	ТШУХ	ХӨСҮТ	НЭМГ/ДЭМТ/ӨЭМТ	ЭМГ/СЭМТ
Эмч, эмнэлгийн ажилтнуудыг аминдэмээр хангах	9-10 дугаар сар	ЭҮТГ	Эрүүл мэндийн байгууллагууд		
Бага насны хүүхдийг "А", "Д" аминдэмээр хангах	9-10 дугаар сар	НЭМГ			
<b>Эмнэлгийн тусламж, үйлчилгээ*</b>					
Шардлагатай эм бэлдмэл, эмнэлгийн тоног төхөөрөмж (яаралтай тусламжийн эм тариа, амьсгалын аппарат, хүчилтөрөгч өтгөрүүлэгч, дуслын шахуурга...)-ийн ашиглалт, хэрэгцээний судалгаа гаргах, бэлэн байдлыг хангах	9 дүгээр сар	ЭҮТГ	ЭМХТ ХӨСҮТ ЭХЭМҮТ	НЭМГ/ДЭМТ/ БОЭТ/НЭ/ӨЭ МТ	ЭМГ/БОЭТ/Н Э/СЭМТ
Лабораторийн оношлуур, урвалж бодис, жижиг хэрэгслийн тооцоог гаргаж, бэлэн байдлыг хангах	9 дүгээр сар	ЭҮТГ	ХӨСҮТ	НЭМГ	ЭМГ
Хамгаалах хувцас хэрэгсэл, халдваргүйтгэлийн бодисын хэрэгцээг тооцож, нөөцлөх	9 дүгээр сар	ЭҮТГ ТШУХ	ХӨСҮТ	НЭМГ	ЭМГ
Томуугийн вирусын эсрэг эм хэрэглэх шалгуурыг боловсруулж, ЭМБ-д хүргүүлэх	9 дүгээр сар		ХӨСҮТ ЭХЭМҮТ		
<b>Эрсдэлийн үеийн харилцаа, холбоо</b>					
Мэдээлэл сургалт, сурталчилгааны төлөвлөгөөний дагуу сурталчилгааны ажлыг зохион байгуулах	9 дүгээр сар	ТШУХ	НЭМҮТ	НЭМГ	ЭМГ
ТТӨ-өөс сэргийлэх хүн амд чиглэсэн мэдээлэл, сурталчилгааны материал, санамж, зөвлөмж, инфографикийг боловсруулах	9 дүгээр сар	ТШУХ	НЭМҮТ	НЭМГ	ЭМГ
Эрүүл мэндийн сэтгүүлчдэд сургалт зохион байгуулах	9 дүгээр сарын 15	ТШУХ	НЭМҮТ	НЭМГ	ЭМГ
<b>II ҮЕ ШАТ. ТОМУУ, ТОМУУ ТӨСТ ӨВЧНИЙ АЛАГ ЦООГ ДЭГДЭЛТИЙН ҮЕ (9 дүгээр сарын 15-аас 11 дүгээр сарын 15)</b>					
<b>Төлөвлөлт зохицуулалт</b>					
Тандалтын мэдээнд үндэслэн эрсдэлийн үнэлгээ хийж, хариу арга хэмжээг зохион байгуулах	Тухай бүр	ТШУХ	ХӨСҮТ	НЭМГ	ЭМГ
Нийгмийн хариуцлагын хүрээнд сургууль, албан байгууллагуудад томуу, томуу төст өвчний хариу арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллах талаар зөвлөмж хүргүүлэх	11 дүгээр сарын 10	ТШУХ			

5 хүртэлх насны хүүхдийн нэн шаардлагатай эмийн хөнгөлөлтийн асуудлыг Даатгалаас санхүүжүүлэх асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлэх	11 дүгээр сарын 15-ны дотор	ЭУТГ			
Томуу, томуу тест өвчнөөр өвчилсөн 5 хүртэлх насны хүүхдээ эмнэлэгт, эсхүл гэрээрээ 3-5 хоног асарсан ажил, хөдөлмөр эрхэлж байгаа эх, эцэг, асран хамгаалагчид цалинтай чөлөө олгох асуудлыг Даатгалаас санхүүжүүлэх асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, шийдвэрлүүлэх	11 дүгээр сарын 15-ны дотор	ТШУХ ЭТГ			
Агаарын бохирдлын индекс өндөртэй бүс нутгийн хүүхдийн байгууллагуудад НЕРА шүүлтүүр, амны хаалтаар хангах арга хэмжээ авах	11 дүгээр сар	НЭМГ ЭТГ			
<b>Тандалт, хяналт</b>					
ТТӨ-ий тандалтыг хийж, бүх шатны ЭМБ-ыг эргэн мэдээллээр хангах	7 хоног тугам	ТШУХ	ХӨСҮТ	НЭМГ/БОЭТ/ ДЭМТ/ НЭ/ӨЭМТ	ЭМГ/БОЭТ/Н Э/СЭМТ/ ӨЭМТ
Хүүхдийн байгууллагад ирцийн тандалт хийх	10-12 дугаар сар	ТШУХ	ХӨСҮТ	НЭМГ	ЭМГ
<b>Эмнэлгийн тусламж, үйлчилгээ*</b>					
ӨЭМТ-ийн ажлын цагт зохицуулалт хийж, хуваарь гарган, уртасгасан цагаар ажиллуулах	Тухай бүр	ЭТГ		НЭМГ/ ӨЭМТ	ЭМГ/СЭМТ/Ө ЭМТ
Эрсдэлт бүлгийн хүн амд (жирэмсэн эх, 5 хүртэлх насны хүүхэд, 65-аас дээш насны өндөр настан, архаг хууч өвчтэй хүн) хийх өрхийн эмчийн үзлэгийн давтамжийг нэмэгдүүлэх	Тухай бүр	ЭТГ		НЭМГ/ӨЭМТ	ЭМГ/СЭМТ/Ө ЭМТ
Түргэн тусламжийн машин, эмчийн тоог нэмэгдүүлэх	Тухай бүр	БТГ ЭТГ		НЭМГ	ЭМГ
ТТӨ, амьсгалын замын цочмог хүнд халдвартай өвчний эмчилгээний зөвлөмжийг тухай бүр шинэчлэн, ЭМБ-д хүргүүлэх	11 дүгээр сар	ЭТГ	ЭХЭМҮТ ХӨСҮТ		

Үүсгэгчийн онцлогоос шалтгаалж, амьсгалын замын цочмог хүнд халдвартай өвчтөний, ялган оношилгооны талаар зөвлөмжөөр хангах, хэрэгжүүлэх	11 дүгээр сар	ЭТГ	ЭХЭМҮТ ХӨСҮТ	НЭ/ӨЭМТ	БОЭТ/НЭ /СЭМТ/ ӨЭМТ
<b>Эрсдэлийн үеийн харилцаа, холбоо</b>					
Хүн амд чиглэсэн мэдээлэл сурталчилгаа хийх	9-11 дүгээр сар	ТШУХ	НЭМҮТ	НЭМГ	ЭМГ
Хүүхдийн байгууллагад тодорхой давтамжтайгаар эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг хийх, зөвлөгөө өгөх	10-12 дугаар сар	ЭТГ	ХӨСҮТ	НЭМГ	ЭМГ
Эрүүл мэндийн байгууллагуудтай цаг үеийн асуудлаар аудио болон видео хурал зохион байгуулах	Тухай бүр	ТШУХ	ХӨСҮТ ЭМХТ		
Агаарын бохирдлын индекс өндөртэй бүс нутгийн хүн амд чиглэсэн мэдээлэл сурталчилгааны материал боловсруулан түгээх	11 дүгээр сар	ТШУХ	НЭМҮТ		
III ҮЕ ШАТ. ТОМУУ, ТОМУУ ТӨСТ ӨВЧНИЙ БҮС НУТГИЙН ХЭМЖЭЭНИЙ ДЭГДЭЛТИЙН ҮЕ (11 дүгээр сарын 16-аас 12 дугаар сарын 15)					
<b>Төлөвлөлт, зохицуулалт</b>					
Эмч, эмнэлгийн мэргэжилтнийг нэмэлтээр ажиллуулах шийдвэр гаргах	Тухай бүр		Эрүүл мэндийн байгууллагууд		
ОУ-ын байгууллагаас дэмжлэг хүсэх (вирусын эсрэг эм, оношлуур, г.м), хамтран ажиллах	Тухай бүр	ЭҮТГ ТШУХ	ХӨСҮТ ЭХЭМҮТ		
Шуурхай удирдлагын нэгж идэвхжиж, тохиолдлын удирдлагын тогтолцоо ажиллаж эхлэх	Тухай бүр	ТШУХ	ХӨСҮТ НЭМҮТ	НЭМГ	ЭМГ
<b>Тандалт, хяналт</b>					
ТТӨ-ий тандалтыг идэвхжүүлж, эрсдэлийн үнэлгээ хийх	Тухай бүр	ТШУХ	ХӨСҮТ	НЭМГ	ЭМГ
Хүүхдийн байгууллагын нягтралыг бууруулах талаар зөвлөмж гаргах	11 дүгээр сар	ТШУХ	ХӨСҮТ	НЭМГ	ЭМГ
Эмнэлгийн эргэлт, хөдөлгөөнийг хязгаарлах	Тухай бүр	ЭТГ	Эрүүл мэндийн байгууллагууд		
<b>Эмнэлгийн тусламж, үйлчилгээ*</b>					
Өрхийн эмчийн үзлэгийг гэрийн үйлчилгээнд бүрэн шилжүүлэх	Тухай бүр	ЭТГ	ХӨСҮТ ЭМЭХҮТ	НЭМГ/ДЭМТ/ ӨЭМТ	ЭМГ/БОЭТ/Н Э/СЭМТ/ ӨЭМТ
Эмнэлэгт хэвтэх шалгуурыг нарийвчлан шаардлагагүй хэвтэлтийг багасгах чиглэлээр зөвлөмж хүргүүлэх	12 дугаар сар	ЭТГ			

Хүүхдийн орыг нэмэх, бусад тасгийн үйл ажиллагааг түр зогсоон, хүүхдийн тусламж үйлчилгээнд шилжүүлж, хүүхдийн орыг 30-65 хувиар нэмэгдүүлэх* (хүснэгт 2)	Тухай бүр	БТГ ЭТГ		НЭМГ/ДЭМТ/ НЭ	ЭМГ/БОЭТ/Н Э/СЭМТ
Жирэмсний үзлэг хяналт, дархлаажуулалтын үйл ажиллагааг зохицуулах	Тухай бүр	ЭТГ	ХӨСҮТ	НЭМГ	ЭМГ
Үйлчлүүлэгч бүрт амны хаалт хэрэглүүлж хэвших	Тухай бүр		Эрүүл мэндийн байгууллагууд		
<b>Эрсдэлийн харилцаа холбоо</b>					
Зөвлөгөө өгөх нээлттэй утас ажиллуулах	Тухай бүр	ТШУХ	ХӨСҮТ ЭХЭМҮТ	НЭМГ/ДЭМТ	ЭМГ/БОЭТ/ НЭ
ТТӨ-ий өнөөгийн байдал, хэрэгжүүлж буй арга хэмжээ, сэргийлэлтийн чиглэлээр гол мэдээлэл (talking point)-ийг шинэчилж, түгээх	7 хоног тутам	ТШУХ	ХӨСҮТ	НЭМГ	ЭМГ
Хүн амын ойлголт, хандлагын судалгаа хийх	7 хоног тутам	ТШУХ	НЭМҮТ	НЭМГ	ЭМГ
<b>IV ҮЕ ШАТ. УЛСЫН ХЭМЖЭЭНИЙ ТОМУУ, ТОМУУ ТӨСТ ӨВЧНИЙ ДЭГДЭЛТИЙН ҮЕ (12 дугаар сарын 16-аас 3 дугаар сарын 1)</b>					
<b>Төлөвлөлт, зохицуулалт</b>					
Орон нутгийн Засаг захиргааны байгууллага, БСШУСЯ-тай хамтран тархвар судлалын арга хэмжээ авах	Тухай бүр	ТШУХ	ХӨСҮТ	НЭМГ	ЭМГ
Резидент эмч нар (757), өндөр настны тэтгэврийн эмч нарыг ӨЭМТ-ийн тусламж үйлчилгээнд дайчлан ажиллуулах	Тухай бүр	ТЗУГ ЭТГ	ЭМХТ	НЭМГ	
Шаардлагатай тохиолдолд орон нутагт мэргэжлийн баг томилон ажиллуулах	Тухай бүр	ТШУХ	ХӨСҮТ ЭХЭМҮТ		
<b>Тандалт, хяналт</b>					
Томуугийн үүсгэгчийн хэвшинжийг тогтоож, шаардлагатай тохиолдолд ДЭМБ-ын лавлагаа лабораторит баталгаажуулах	Тухай бүр	ТШУХ	ХӨСҮТ		
Хүүхдийн байгууллагыг түр хаах, үзвэр үйлчилгээ, нийтийн цуглааныг хязгаарлах арга хэмжээг холбогдох байгууллагатай хамтран хэрэгжүүлэх	Тухай бүр	ТШУХ	ХӨСҮТ	НЭМГ	ЭМГ
Эмнэлгийн халдварын сэргийлэлт, хяналтын байдалд тандалт хийх, хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэл гаргах	Тухай бүр	НЭМГ	ХӨСҮТ		
<b>Эмнэлгийн тусламж, үйлчилгээ*</b>					

Насанд хүрэгчдийн зарим тасгийн үйл ажиллагааг хүүхдийн тусламж үйлчилгээнд шилжүүлэх, хүүхдийн орны тоог 80-95 хүртэл хувиар нэмэгдүүлэх	Тухай бүр	БТГ ЭТГ	ХӨСҮТ	ДЭМТ	НЭ
Улсын 2 дугаар төв эмнэлэг, Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг, бусад хувийн хэвшлийн эмнэлгүүдэд нэмэлт эмнэлэг дэлгэх	Тухай бүр	БТГ ЭТГ	ХӨСҮТ ЭХЭМҮТ	НЭМГ	
<b>Эрсдэлийн үеийн харилцаа холбоо</b>					
Хүн амд чиглэсэн мэдээлэл сургалт, сурталчилгааг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр өдөр бүр тогтмол хийх	Тухай бүр	ТШУХ	НЭМҮТ ХӨСҮТ	НЭМГ	ЭМГ
ТТӨ-ий өнөөгийн байдал, хэрэгжүүлж буй арга хэмжээ, сэргийлэлтийн чиглэлээр гол мэдээлэл (talking point)-ийг шинэчилж, түгээх	7 хоног тутамд	ТШУХ	ХӨСҮТ	НЭМГ	ЭМГ
Хүн амын ойлголт, хандлагын судалгаа хийх	7 хоног тутамд	ТШУХ	НЭМҮТ	НЭМГ	ЭМГ
Цаг үеийн байдлаар хэвлэлийн бага хурал хийж, сэтгүүлчдийг мэдээллээр хангах	Тухай бүр	ТШУХ	НЭМҮТ	НЭМГ	ЭМГ

--- 000 ---

Хүснэгт 2. Хүүхдийн орны ачаалал, шаардлагатай орны тооцоо

№	Аймаг	Нийт орны тоо	Хүүхдийн орны тоо	Шаардагдах хүүхдийн орны тоо [орны ачаалал нэмэгдэх хувиар]									
				10%	20%	30%	40%	50%	60%	70%	80%	90%	100%
1	Архангай	519	91	9	18	27	36	46	55	64	73	82	91
2	Баян-Өлгий	728	76	8	15	23	30	38	46	53	61	68	76
3	Баянхонгор	525	92	9	18	28	37	46	55	64	74	83	92
4	Булган	376	57	6	11	17	23	29	34	40	46	51	57
5	Говь-Алтай	439	68	7	14	20	27	34	41	48	54	61	68
6	Говьсүмбэр	118	17	2	3	5	7	9	10	12	14	15	17
7	Дархан-Уул	742	100	10	20	30	40	50	60	70	80	90	100
8	Дорноговь	438	67	7	13	20	27	34	40	47	54	60	67
9	Дорнод	538	65	7	13	20	26	33	39	46	52	59	65
10	Дундговь	301	57	6	11	17	23	29	34	40	46	51	57
11	Завхан	574	86	9	17	26	34	43	52	60	69	77	86
12	Орхон	650	59	6	12	18	24	30	35	41	47	53	59
13	Өвөрхангай	716	121	12	24	36	48	61	73	85	97	109	121
14	Өмнөговь	446	82	8	16	25	33	41	49	57	66	74	82
15	Сүхбаатар	365	56	6	11	17	22	28	34	39	45	50	56
16	Сэлэнгэ	708	123	12	25	37	49	62	74	86	98	111	123
17	Төв	523	88	9	18	26	35	44	53	62	70	79	88
18	Увс	571	110	11	22	33	44	55	66	77	88	99	110
19	Ховд	566	94	9	19	28	38	47	56	66	75	85	94
20	Хөвсгөл	788	150	15	30	45	60	75	90	105	120	135	150
21	Хэнтий	494	92	9	18	28	37	46	55	64	74	83	92
<b>Аймгийн дүн</b>		<b>11125</b>	<b>1751</b>	<b>177</b>	<b>348</b>	<b>526</b>	<b>700</b>	<b>880</b>	<b>1051</b>	<b>1226</b>	<b>1403</b>	<b>1575</b>	<b>1751</b>
22	Улаанбаатар	11835	789	79	158	237	316	395	473	552	631	710	789
<b>Улсын дүн</b>		<b>22960</b>	<b>2540</b>	<b>256</b>	<b>506</b>	<b>763</b>	<b>1016</b>	<b>1275</b>	<b>1524</b>	<b>1778</b>	<b>2034</b>	<b>2285</b>	<b>2540</b>

Эх сурвалж: Эрүүл мэндийн статистик мэдээ, 2016, ЭМХТ

**\*Хүснэгт 3. ТТӨ-ий эрсдэлээс сэргийлэх бэлэн байдлын төлөвлөгөөг хэрэгжүүлэх зураглал  
(Эмнэлгийн тусламж үйлчилгээ)**

Хариу арга хэмжээ	Эрүүл мэндийн байгууллага	ТТӨ-ий дэгдэлтийн үе шат		
		I	II	III
Амбулаторийн үзлэг	ӨЭМТ СЭМТ	Уртасгасан цагаар ажиллана	Өрхийн эмчийн үзлэгийг гэрийн эргэлтэд шилжүүлнэ	IV
	ДЭМТ БОЭТ АНЭ	Хэвийн горимоор ажиллана	Хэвийн горимоор ажиллана.	- Эмнэлгийн эргэлт, хөдөлгөөнийг хязгаарлана. - Эмнэлгийн халдварын сэргийлэлтийн үйл ажиллагааг эрчимжүүлнэ.
	ЭХЭМҮТ	Хэвийн горимоор ажиллана	Өрхийн эмчийн үзлэгийн эргэлтийн давтамжийг нэмэгдүүлнэ.	Жирэмсний үзлэг хяналт, дархлаажуулалтын үйл ажиллагааг зохицуулна.
Эрсдэлт бүлгийн хяналт	ӨЭМТ СЭМТ	Хэвийн горимоор ажиллана	Хэвийн горимоор ажиллана	
Түргэн тусламжийн дуудлага	БОЭТ ДЭМТ АНЭ	Хэвийн горимоор ажиллана.	Зөвлөгөө өгөх нээлттэй угас ажиллуулна.	Түргэн тусламжийн машин, эмчийн тоог нэмэгдүүлнэ.
	ДЭМТ АНЭ ЭХЭМҮТ	Хэвийн горимоор ажиллана.	Үзлэг, оношилгоог нарийвчилна	Эмнэлэгт хэвтэх шалгуурыг нарийвчилна.
Эмнэлгийн орны зохицуулалт	ДЭМТ АНЭ ЭХЭМҮТ	Хэвийн горимоор ажиллана.	Насанд хүрэгчдийн тасгийн 30 хүртэл хувийг хүүхдийн оронд шилжүүлнэ.	Зарим насанд хүрэгчдийн тасгийн үйл ажиллагааг түр зогсоож, хүүхдийн тусламж үйлчилгээнд шилжүүлэх.
	ДЭМТ АНЭ ЭХЭМҮТ	Хэвийн горимоор ажиллана.	Насанд хүрэгчдийн тасгийн 30-65 хүртэл хувийг хүүхдийн тусламж үйлчилгээнд шилжүүлнэ.	Хүүхдийн орны тоог 95 хувь хүртэл нэмэгдүүлнэ. Хувийн эмнэлгийг нэмэлтээр ашиглана
	ӨЭМТ	Хүний нөөцийг сургах, төлөвлөх	ӨЭМТ-ийн эмч нарыг уртасгасан цагаар ажиллуулна Сургагдсан эмч мэргэжилтнийг дайчлан ажиллуулна.	Резидент эмч нарыг дайчлан ажиллуулна. Шаардлагатай тохиолдолд өндөр настны тэтгэврийн эмч нарыг дайчлан ажиллуулж болно.
Хүний нөөцийн зохицуулалт	ДЭМТ АНЭ ЭХЭМҮТ			